

<http://mongol.cri.cn/21/2006/05/31/43@63997.htm>

GMT+08:00) 2006-05-31 16:44:40

Сурвалжлагч: О.Дарамбазар/ Хятадын Олон Улсын Радио

Солонгос судлал болон монгол судлалын харьцаа холбооны асуудалд



2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн доктор, профессор Б. Сумьяабаатар Бээжин Их Сургуулийн доктор, дэд профессор Дулаантай хамт байгаа нь

Дэлхий нийтийн хэмжээний эрдэм шинжилгээний бие даасан том чухал салбар болсны хувьд, монгол судлалын цар хүрээ нь улмаар өргөжин тэлж хир түвшин нь байнга өндөржин дээшилсээр байгаагийн нэг илрэл нь монгол судлалын асуудлыг зөвхөн Монгол үндэстний хүрээнд л биш харин түүний түүхэн бодит байдалд нь тавьж, Монгол үндэстэнтэй харилцаа холбоотой байсан улс үндэстнүүдийн түүхтэй холбож гүнзгийрүүлэн судалж байгаа явдал юм. Энэ талаар дээр үеийн ахмад эрдэмтэд үлэмжхэн ажлуудыг хийж маш их ололт амжилтанд хүрсэн юм.

2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэнгийн Солонгос Судлалын Төвийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Б. Сумьяабаатар багшийг урилгаар Хятад улсын Бээжин Их Сургуулийн Монгол Судлалын Төвд зочилж лекц хийж байсан хугацаанд нь Хятадын Олон Улсын Радиогийн сурвалжлагч

О.Дарамбазар түүнтэй уулзаж, эрдэм шинжилгээний байдлынх нь талаар сонирхож ярилцсан юм.

Сурвалжлагч: Багш та уул нь ажил хэргээр Хятад улсад ирж байсан уу?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Би Хятад улсад олон удаа ирж байсан. Солонгос руу явахдаа Бээжин хотоор дамжиж явж байсан юм.

Сурвалжлагч: Та хамгийн анх аль онд Хятад улсад ирж байсан бэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Хятад улсад 1955 онд анх ирсэн байх.

Сурвалжлагч: Ер нь маш эрт дээр үед ирж байсан юм байна. Энэ удаа та ямар ажил хэргээр явж байгаа вэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Би саяхан Зүүн Азийн судлалын эрдэм шинжилгээний бага хуралд 3 хоног оролцлоо. Тэгээд Бээжин Их Сургуулийн Монгол Судлалын Төвд Дулаан багшийн урилгаар ирж хэд хоног лекц уншсан юм.

Сурвалжлагч: Бээжин Их Сургуулиас гадна бас Бээжинд байгаа бусад их дээд сургуулиудад лекц уншсан уу?



2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн доктор, профессор Б. Сомьяабаатар Бээжин Их Сургуульд эрдэм шинжилгээний солилцоо хийж байгаа нь

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Бээжин Их Сургуулийг би их хүндэлдэг юм. Энэ онд Бээжин Их Сургуулийн 108 жилийн ой болж байгаа гэж би бодож байна. 108 гэдэг үг бол манай Монголд их хүндтэй тоо байдаг, эрх 108, Эрдэнэ-зуугийн суврага 108 гэх мэтээр монголчууд маань энэ тоог маш их бэлэг дэмбэрэлтэй тоо гэж үздэг. Бээжин Их Сургуулийн 108 жилийн ой тохиож байгаа явдалд их баяртай байна. Би энэ удаа Бээжин Их Сургуулиас гадна бас Төвийн Үндэстний Их Сургуульд очиж Солонгос судлал ба Монгол судлалын харьцаа холбооны

тухай лекц уншсан. Солонгос судал нь Монгол судалтай яаж холбогддог юм бэ? Солонгос судлалаас Монгол судлалд юу өгдөг юм бэ? Түүний шинжлэх ухааны ач холбогдол нь юу юм бэ? гэдэг талаас нь би ярьсан юм.

Сурвалжлагч: Багш та өөрөө Монгол-Солонгосын харилцааны талаар түлхүү судалж байгаа юм байна. Энэ чиглэлээр та ямар ямар бүтээлүүд бичиж хэвлүүлсэн бэ?

Доктор, профессор Б.Сумьяабаатар: Ер нь Монгол дахь Солонгос судлал нь 13-р зууны үеэс эхтэй гэдэг юм. Энэ 20-р зууны үед орж ирээд тухайлбал 1960-аад онд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын Хүрээлэнд Солонгос судлал үүсч бий болсон гэж эрдэмтэд үздэг. Тэр үед Солонгос судлал нь төнгөж эхэлж байсан, одоо гэхэд энэ талаархи сургууль, судлалын ажил Монгол улсад маш их идэвхтэй өрнөж байна. Солонгос Судлал бол Монгол судлалд маш их ач холбогдолтой гэж би боддог. 13-р зууны үед Монголоос илгээсэн 100 гаруй захидал харилцааны бичиг, жуу бичиг, хааны зарлиг бичиг Солонгосын түүхийн тэмдэглэлд үлдсэн байдаг юм. Тэдгээр нь тэнд солонгос орчуулгаараа үлдсэн байдаг. Энэ бол эрдэм шинжилгээний маш ховор баримт хэрэглэгдэхүүн болдог, бусад газар орны түүхэн тэмдэглэлд байдаггүй зүйл түүнд мөн маш олон тэмэглэгдсэн байдаг юм. Жишээлбэл 1221 онд өөрөөр хэлбэл "Монголын нууц товчоон" зохиогдохоос 20-иад жилийн өмнө, Солонгост Монголоос нэг жуу бичиг илгээсэн байна. Түүнийг зарлиг бичиг хэмээн нэрэлдэг. 1221 он бол Чингис хааны үе, Чингис хаан суугаад арван зургаахан жил болж байсан үе юм. Тэр захидал бичиг нь маш сонин агуулгатай байлаа. Юу гэсэн бэ гэвэл Солонгос тухайлбал тэр үеийн Гууль улсад манай улсад бийр бэх, бичгийн цаас илгээ гэсэн байдаг. Тэгэхтэй зэрэг, тэр нь 1221 он гэхэд монголчууд гаднаас бийр бэх, бичгийн цаас өөрөөр хэлэх юм бол бичгийн хэрэглэдэхүүн авахаар тийм их соёлтой байжээ гэдгийг харуулсан байгаа юм. Мөн зөгөөр л энгийн зүйл нэхээгүй мөртөө бас бэхэн дотроо "Лунтуань" гэдэг луутай бэхээ илгээ гэсэн байсан, гэгэхлээр энэ тухай монголчууд тэр үед маш нарийн мэдэж байсан гэдэг нь тодорхой. 1221 оны энэ захидлыг Монголын 13 хүн хүргэж очсон бөгөөд тэдний нэг нь эмэгтэй хүн байлаа гэж Солонгосын түүхэн бичигт бичсэн байна. Тэгэхтэй зэрэг, энэ нь бас 13-р зууны үед Монголын эмэгтэй хүн элч болж гадаад оронд явж байсан гэсэн сонин түүх болж байгаа юм. Энэ бол дэлхийн дипломат харилцааны түүхэнд ч орох сонин үйл хэрэг болно гэж би үзэж байна. Мөн Өгөтэй хааны үед тухайлбал 1235 онд Монголоос бас хэдэн элч Солонгост очсон, тэдний нэг нь эмэгтэй хүн байлаа гэж бас тэмдэглэсэн зүйл байдаг. Тэгэхлээр эмэгтэй хүн элч болж явж байсан түүх нь Монголынх бол хамгийн түрүүнийх нь байх гэж би боддог юм.

“与文化交流”国际学术研讨会
Century: Cultural Construction and Cultural Exchange



2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн доктор, профессор Б. Сумьяабаатар Бээжин Их Сургуульд лекц уншиж байгаа нь

Сурвалжлагч: Ингэж бодлоход энэ үйл хэрэг 800 гаруй жилийн түүхтэй болж байгаа юм байна.

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Тийн, 800 гаруй жилийн түүхтэй болж байна. Мөн гаднаас бийр бэх, бичгийн цаас авъя, өөрөөр хэлбэл тэдгээрийг оруулж ирье гэсэн тэр мэдээ ч хүртэл дэлхийд бараг тэргүүн зэрэгт орох болов уу гэж үзэж байна, Гаднаас авъя гэж байгаагийн хувь бол тийм, гэхдээ дотооддоо үйлдвэрлэсэн зүйл зөндөөн байдаг.

Сурвалжлагч: Тэдгээр бичгүүдийг Монголын хаадаас илгээсэн алба татлагын бичиг гэж ойлгож болох уу?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Тийн, Чингисийн үеийн тэр бичгийг тархаах зарлиг гэж нэрэлж байсан бөгөөд түүний дээр нь "Жи" гэсэн үсэгтэй бичиг байсан. Тэгэхлээрээ тэр нь "ирүүл" гэсэн зарлиг бичиг байсан юм.

Сурвалжлагч: Багш та энэ чиглэлээр эрдэм шинжилгээний ямар ямар ном зохиол бичсэн бэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Би энэ талаар Солонгосын түүхэн бичиг дэх Монголтой холбогдолтой зүйлүүдийг монголоор орчуулаад, эртний солонгос эхийг нь тавиад, тайлбар сэлтийн зүйл хавсаргаад, "Монгол Солонгосын харилцааны бичгүүд" гэсэн номыг Монголд нэгийг, бас Сөүл хотод нэгийг тус тус хэвлүүлсэн юм. Мөн "Монгол Солонгосын харилцаа" гэсэн ганц сэдэвт зохиол нэгийг бичсэн. Ер нь Монгол Солонгосын харьцааны судлалын чиглэлээр хэд хэдэн ном өгүүлэл гаргасан юм. Үүнээс гадна, би 1990 онд "Монголын нууц товчоон"-ы нангиад эх, түүнийг оюут (компьютерийг Б.Сумьяабаатар багш ингэж нэрэлсэн байдаг) -ад оруулах код, монгол үсгийн сэргээлт, ром үсгийн галиг энэ бүгдийг оюутад оруулаад 960 хуудастай "Монголын нууц товчоон"-ыг гаргасан. " Монголын нууц

товчоон'-ы хэлбэр судлал" гэдэг 3600 гаруй хуудастай номыг бас би монгол солонгос хоёр хэлээр хэвлүүлсэн юм. Энэ ном 1997 онд хэвлэгдсэн. Үүндээ би "Монголын нууц товчоон"-ыг 571 ханьзы үсгээр тэмдэглэжээ гэсэн бөгөөд тэдгээрийг дотор нь задлаад 571 ханьзы үсгийн үгийн эхэнд, дунд, адагт орсон, бас хэдэн удаа орсон, ямар монгол үгийг тэмдэглэхэд орсон бэ? зэргийг бүгдийг нь тэмдэглэж гаргасан юм.



2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн доктор, профессор Б. Сумьяабаатар Бээжин Их Сургуульд оюутдын сонирхсон асуултанд хариулж байгаа нь

Сурвалжлагч: Багш таны хийсэн энэ ажлыг маш сонирхолтой ажил гэж бодож байна. Ер нь Хятад улсад ч гэсэн, "Монголын нууц товчоон"-ы талаар судалсан зүйл их байгаа, гэхдээ багш таны судалсан шиг ийм бүтээл тун ховор байгаа юм.

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Тийм байж магадгүй, миний хэвлүүлсэн тэр номыг тун ховор зүйл боллоо гэж гаднын эрдэмтэд ярьдаг юм. Ханьзы үсгээр монгол үгийг тэмдэглэхэд үгийн эхэнд орсон нь хэд вэ? Адагт орсон нь хэд вэ? Ороогүй нь хэд вэ? гэдгийг тэр номдоо би ялгаж гаргасан юм. Японы нэрт монголч эрдэмтэн профессор Озава багш 8 боть "Монголын нууц товчоон" гаргасан байгаа, гэхдээ яг ингэж хийсэн нь үзэгдээгүй зүйл гэж хэлж болно. Үүнийг Сумьяабаатар ингэж хийлээ гэхээс монгол хүн ингэж хийлээ гэвэл их сонин болох биз ээ.

Сурвалжлагч: Монгол улс дахь монгол судлал болон Хятад улс дахь монгол судлалыг харьцуулбал багш та ямар үнэлгээ өгөх вэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Ер нь манай монголчууд Хятад улсад хийж байгаа монгол судлалыг маш их сонирхдог юм. Хятад улсын эрдэмтэд өргөн их мэдлэгтэй, олон хэлтэй, түүхэн сурвалжийг маш сайн ашигласан, үзсэн харсан хэрэглэгдэхүүнүүдээ эрдэм шинжилгээний бүтээл болгож чаддаг авьяаслаг эрдэмтэд гэж би боддог, манайхан ч их хүндэлдэг юм.

"Монголын нууц товчоон"-ы талаар нэг зүйлийг нэмж хэлэхэд Монголоос нэг сонин олдвор олдсон. "Монголын нууц товчоон"-ыг анх монгол үсгээр хэн галигласан бэ? гэдэг асуудлын талаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэнгийн аман зохиолын сан хөмрөгөөс нэг "Монголын нууц товчоон" гарч ирсэн нь бидний сонирхлыг маш их татсан юм. Тэр нь "Монголын нууц товчоон"-ы хятад орчуулгыг үсэгчлэн монгол үсгээр улаан шунхан бэхээр эхнээс нь адгийг нь хүртэл галиглаж буулгасан зүйл байсан, үүнийг Хятад улсын эрдэмтэд, өвөрлөгч эрдэмтэд үзээд үнэхэр шинэхэн зүйл байна гэж хэлж байсан юм. Түүнийг хэн галигласан бэ? гэдэг нь одоо хир тодорхойгүй байгаа боловч, уг номын дээр нь Судар Бичгийн Хүрээлэн амой гэсэн өгүүлбэр бий. Тэгэхтэй зэрэг, тэр нь 1924—1931 оны хооронд галиглаж дууссан зүйл байх учиртай, уг номыг би Солонгост хэвлүүлсэн. Мөн бас нэг тэмдэглэж хэлэх зүйл бол "Монголын нууц товчоон"-ыг монгол үсгээр хэн анх буулгасан бэ? гэдэг асуудал байгаа юм. Одоог хүртэл, Цэнд гүнг 1917, 1918 оны үеэр монгол үсгээр уг зохиолыг буулгасан гэж эрдэмтэд үздэг байсан, гэтэл саяхан бас нэг "Нууц товчоон" гарч ирсэн, тэр нь 1876 онд Оросын нэг эрдэмтэн "Нууц товчоон"-ыг эхнээс нь монгол үсгээр буулгаад, крил үсгээр галиглаад, догуур нь мөр бүрийг дагуулан оросоор орчуулаад, ар талд нь тайлбар сэлт дагалдуулсан, оюутнуудад зориулж хийсэн бололтой, их ховор сонин зүйл байсан юм. Тэгээд "Монголын нууц товчоон"-ыг "цэр нь цээжиндээ бөөр нь бөгсөндөө хүртэл" тэгэж хийчхсэн байгаа. Түүнийг би Хятад улсад ирэхээсээ өмнөхөн, Улсын Номын Сантай хамжаад хэвлүүлсэн юм. Энэ нь "Монголын нууц товчоон"-ы судлалд сонин зүйл болно гэдэгт найдаж байна.

\О.Дарамбазар сурвалжилж редакторлов.\